

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.БАТЧУЛУУН ТАНАА

2022.02.23 № 149

танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022.02.23 №149

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	21.30	127.50
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	198.20	215.70
	Нийт хөрөнгийн дүн	219.50	343.20
	Нийт өр төлбөрийн дүн	0.20	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	219.30	343.20
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	219.50	343.20
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,547.80	1,513.30
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,502.80	1,389.40
	Үйл ажиллагааны үр дүн	45.00	123.90
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.60	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	44.40	123.90
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219.30	219.30
	Тайлант оны үр дүн		123.90
	Эцсийн үлдэгдэл	219.30	343.20
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,547.60	1,512.70
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,454.20	1,445.50
	Үйл ажиллагааны ЦМГ	93.40	67.20
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	- 92.50	- 67.20
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.90	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,291.10	1,203.30
	Урсгал зардал	1,291.10	1,203.30
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,291.10	1,203.30
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,291.10	1,203.30
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар асуудлыг хэлэлцэж, бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд хурлын зохион байгуулалт хяналт, шалгалт, нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжил, орон нутгийн өмчийн талаар өөрийн онцгой бүрэн эрхийг хадгалж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг Өмнөговь аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар хичээл үйлдвэрлэлийн зардлаас ИТХ-ын албан хаагчдад /6/ "Турк улсад хөдөө аж ахуйн шинэ тоног төхөөрөмжийн чиглэлээр туршлага судлах" унааны зардалд нэг хүн тус бүрд 4.2 сая төгрөгийг шийдэж Эй Стар Монголиа ХХК-д шилжүүлсэн ба туршлага судалсан талаар нотлох баримтгүй, Цахим мэдээллийн урсгал НҮТББ, Ти Жи Эн Эс анлимитед групп ХХК-тай худалдах худалдан авах гэрээ байгуулаагүй ямар ажил, үйлчилгээ худалдан авсан талаарх мэдээлэл нь анхан шатны баримтаар тодорхойлогдохгүй нийт 69.7 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас тус тус зарцуулсан нь төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн зарчимтай нийцээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

ИТХ-ын бүрэн эрх, санхүү төсвийн үйл ажиллагаа нь зарим талаараа Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-той зөрчилдөж байгаа ч төрийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх ёстой гэсэн зарчмыг баримталж ажилласан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 150 мэдээлэл байршуулахаас 2 мэдээлэл хугацаа хоцруулан байршуулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг бүрэн оруулаагүй, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 187.7 сая төгрөгийн худалдан авалтын 21 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 85.4 сая төгрөгийн 2 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 120.0 сая төгрөгийн 2 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.1.6, 6.4.4, 6.4.5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал болон ИТХ-ын даргын нөөц сангаас нийтдээ 29,651,190

төгрөгийн машин тоног төхөөрөмж, 32,756,149 төгрөгийн тавилга эд хогшил, 2,500,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 8,710,000 төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн, Монголын залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 101 жилийн ойг тэмдэглэх төлөвлөгөөний дагуу "Монголын залуучуудын холбоо" НҮТББ хамтарч төлөөллийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын албан томилолтын зардалд 6,276,000 төгрөг, Ноён сумын тэмээний баяр арга хэмжээнд 5,000,000 төгрөг, шатрын тэмцээнд 2,544,000 төгрөг, Даян хааны отог ТББ-д буудлагын тэмцээнд 8,000,000 төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн тэмцээнд 5,850,000 төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/, 1.5 /салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх/, 1.7 /хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх/-д заасантай тус тус нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хэвлэл мэдээллийн зардлын зарцуулалтыг холбогдох эрхзүйн шийдвэр болон анхан шатны баримттай тулган баталгаажуулах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 845.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 222.9 сая төгрөгийн алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 618.4 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх 1 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	6	348.5	3	222.9	1	3.9	1	121.7	1	
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	2	496.7							2	496.7
3	Нийт дүн	8	845.2	3	222.9	1	3.9	1	121.7	3	496.7